

**2019 ОНЫ 06 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛААР
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2019.06.21

№17

Дархан

№	Өгсөн үүрэг даалгавар	Хэрэгжилт	Хариуцах хэлтэс, агентлаг
1.	<p>Өнгөрсөн 7 хоногоос сайд нартай байгуулсан үр дүнгийн гэрээний 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг дээд газарт явуулж эхэлсэн. Аймгийн Засаг дарга салбарын сайдтай байгуулсан гэрээний биелэлтэд 30 хувийн гүйцэтгэлтэй 5 арга хэмжээ явсан. Мөн сайдай байгуулсан гэрээний хангалтгүй үнэлэгдсэн зүйл, заалтуудын хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс сайн хяналт тавьж анхаарч ажиллах хэрэгтэй байна. Цаашид хангалтгүй үнэлэгдсэн заалтуудын хэрэгжилтийг сайжруулахад анхаарах хэрэгтэй.</p>	<p>2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар аймгийн Засаг дарга Батлан хамгаалах яамны сайдтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 5 бүлэг, 30 арга хэмжээний биелэлт 71.66% буюу 3.58 оноо, Хууль зүй дотоод хэргийн сайд 10 бүлэг, 18 арга хэмжээний биелэлт 68.75% буюу 3.44 оноо, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 23 арга хэмжээний биелэлт 85.21% буюу 4.26 оноо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 5 бүлэг 21 арга хэмжээний биелэлтэд 67.4% буюу 3.36 оноо, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээний Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах №19-001 тоот гэрээний 1 дүгээр хавсралт 8 бүлэг 19 арга хэмжээний биелэлтийн ХШҮ-ний дүн 62.28% буюу 3.46 оноо, №19-001 тоот гэрээний 2 дугаар хавсралт 8 бүлэг 43 арга хэмжээний биелэлтийн ХШҮ-ний дүн 75.83% буюу 3.79 оноо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байгуулсан 9 бүлэг 38 заалтын хэрэгжилтэд 77.36% буюу 3.86 оноотой үнэлэгдэж холбогдох бодлогын хэлтсүүдэд тус тус хүргүүлсэн.</p>	<p align="center">Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс</p>
2.	<p>Монгол улсын Ерөнхий сайд Дархан-Уул аймагт Дархан Улаанбаатар чиглэлийн авто замын нээлтийн үйл ажиллагаанд оролцохоор өнөөдөр ирэх гэж байна. Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга оролцоо хангаж ажиллана. Хөрөнгө оруулалт,</p>	<p>Дархан Улаанбаатар чиглэлийн авто замын нээлтийн үйл ажиллагаа 2019.06.17-ны өдөр болсон. Нээлтийн үйл ажиллагаанд Ерөнхий сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, УИХ-ын гишүүд Д.Хаянхярваа,</p>	<p align="center">Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого</p>

	<p>хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс Найрамдал талбайн тохижилтын ажлын зураг төсвийг боловсруулалтад хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна. 2020 оны хамгийн эхний тендер зарлах ажил бол талбайн тохижилт байна. Иймд уг ажлын зураг төсвийг хийгээд магадлалаар оруулаад тендерийг нь зарлах хэрэгтэй. 2020 оны 04 дүгэр сарын 15-ны өдөр уг ажлыг эхлүүлнэ. Мөн талбайн тохижилтын ажил, гэрэлтүүлгийн ажилд анхаарах хэрэгтэй байна.</p>	<p>Б.Жавхлан, Б.Баттөмөр болон Зам, тээврийн хөгжлийн яамны төлөөллүүд, төслийн нэгж болон аймгийн удирдлагууд оролцлоо. Эхний ээлжинд авто замын зогсоолын зураг төсөв боловсруулах ажил 90 хувьтай явагдаж байна. Талбайн тохижилтын ажлын зураг төсвийг боловсруулахад хяналт тавьж ажиллана.</p>	<p>ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС</p>
<p>3.</p>	<p>Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлыг сайн хангаж ажиллах хэрэгтэй байна. Урьдчилсан шалгалтаар Шарын гол, Орхон суманд ажиллахад хангалтгүй үнэлгээ авсан байна. Алдаа, дутагдлыг засаж сайжруулж ажиллах хэрэгтэй байна. Иймд Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Алтанчимэг хангалтгүй үнэлгээ авсан байгууллагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч үр дүнг нь дараагийн аймгийн Засаг даргын Шуурхай хуралд танилцуулах хэрэгтэй байна.</p>	<p>Аймгийн салбар комиссын урьдчилсан үзлэгт Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн газар, Захирагчийн алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 435 дугаар хаалттай хорих анги, Улсын бүртгэлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Статистикийн хэлтэс, Аймгийн ИТХ, Боловсрол соёл, урлагын газар, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Стандартчлал хэмжил зүйн хэлтэс, Аймгийн ЗДТГ, Аймгийн ИТХурал, Шарын гол сумын 2 дугаар дунд сургууль, 6 дугаар дунд сургууль, 19 дүгээр цэцэрлэг, 2 дугаар цэцэрлэг, 18 дугаар цэцэрлэг, 14 дүгээр цэцэрлэг /нийт 20 байгууллага/ хамрагдаж Хууль зүй дотоод хэргийн сайдын баталсан 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэн илэрсэн зөрчил дутагдлыг дор бүр нь танилцуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаас гадна Боловсрол соёл урлагийн газрын дэд ажлын хэсэг болон Шарын гол сумын дэд ажлын хэсгийн гишүүдэд үзлэг хэрхэн явуулах, ажлын үзүүлэлт аргачлалыг хэрхэн дүгнэх талаар тайлбарлан дэд ажлын хэсгүүдийн үзлэг шалгалтыг эхлүүлэн мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр ханган ажиллаж байна.</p> <p>Шарын гол сумын ИТХурал, Шарын гол сумын ЗДТГгазар, ШШГЕГ-ын харъяа 435 дугаар хаалттай хорих анги, Аймгийн стандарт хэмжил зүйн хэлтэс,</p>	<p>Хууль, эрх зүйн хэлтэс, Архивын тасаг</p>

		Аймгийн ус цаг уур орчин шинжилгээний төвд үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар хугацаатай зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.	
4.	Элсэлтийн ерөнхий шалгалт өнөөдөр эхэлж байна. Мөн элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалтад сайн анхаарч ажиллах хэрэгтэй байна. Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Төрийн албаны тухай хуулийн хүрээнд цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлууд болон бусад холбогдох албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтад хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна. Ингээд 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр болоход орон тоо нь суларсан сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалт дуусч ажилдаа орсон байх ёстой. БСШУЯ-ны сайд Дархан-Уул аймагт ажиллах үеэр боловсролын байгууллагын ажилтнуудын хэлсэн санал, шүүмжлэлд анхаарч ажиллах хэрэгтэй байна.	Орон тоо нь суларсан сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн 12 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан сонгон шалгаруулалтын журмыг хүлээж байна. Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, баталжуулахад бэлэн болсон. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам эцэслэгдээгүй байна. Сонгон шалгаруулалтын бүртгэлд НБХ хяналт тавьж ажиллана.	Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар

ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.НАСАНБАТ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.ЗОЛЖАРГАЛ